



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 01 сарын 13 өдөр

Дугаар 08/08

Мандалговь

“5, 9, 12, 13-р байрнуудын гадна тохижилт,  
тоглоомын талбайн ажил”-ын гүйцэтгэгчийг  
сонгон шалгаруулах үнэлгээний  
хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “5, 9, 12, 13-р байрнуудын гадна тохижилт, тоглоомын талбайн ажил”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Э.Чагнаадорж (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга)

Гишүүд:

Ц.Бямбацогт (Иргэний төлөөлөл)

Х.Анхбаяр (ХТГ-ын дарга)

Н.Сүхбаатар (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

М.Бат-Эрдэнэ (Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

Хоёр. Тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хорооны дарга (Э.Чагнаадорж)-д даалгасугай.

Гурав. Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (М.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ЭРДЭНЭСҮРЭН

482060018